

УЛАМЖЛАЛТ ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН СУРВАЛЖУУД ДАХЬ
ГУНГААЖАЛЦАНЙ 44, ЧОЙЖИ-ОДСЭРИЙН 123 ҮСЭГ
ГЭДЭГ ОЙЛГОЛТЫН ТОДРУУЛГА

Д. Заяабаатар *

Монгол хэлшинжлэлийг түүхчлэн өгүүлэхэд Саж бандид Гунгаажалцаны “Зүрхний толт”, бандид Чойжи-Одсэрийн “Зүрхний толтын тайлбар” хэмээх хэлзүйн бүтээлүүд түүчээ болдог. Эл өгүүлэлд эдгээр дуун ухаанчийн заан тодорхойлсон монгол үсгийн цагаан толгойн бүрэлдэхүүний учир холбогдлын талаар нэхэн шинжилнэ.

Өдгөө бидний мэдлэгийн хирээр хамгийн эртний хэлзүйн бичиг болох “Зүрхний толт”-ыг зохиосон хүн бол 13-р зууны үед амьдарч, зохиол бүтээлээ туурвиж асан дуун ухаанч Саж бандид Гунгаажалцан юм. Гунгаажалцан Годан хаантай тахилын орон, өглөгийн эзэн бололцож, Монгол газраа шашин номын үйл эрхэлж суусан тухай тодорхой мэдээг “Эрдэнийн товч”-д тэмдэглэсэн байна. Тэнд “*Тэр Сажа бандид хэмээвээс, ...хар бар жилээ (1182 он) төрж...жаран гуравнаа хөх луу жилээ (1244 он) өөд болж, жаран зургаанаа улаагчин хонин жилээ (1247 он) хаан лугаа (Годан хаан Д.З) золгоод... далан наснаа, цагаагчин гахай жилээ (1251 он)... лам, өглөгийн эзэн хаан хоёр нэгэн жилээ өөд болбой хэмээюү*”¹ гэжээ. Тэрбээр Годан хааны дэргэд монгол нутагт суух хугацаанд монгол хэлийг судлан шинжилж, энэтхэг төвдийн хэлшинжлэлийн дэгт суурилсан монгол хэл судлалын нэгэн бүтээл “Зүрхний толт” хэмээх хэлзүйн бичгийг зохиожээ.

Энэ ташрамд Саж бандид Гунгаажалцан монгол бичгийг хэдэргэний дүрсээр бэлгэдэн зохиосон гэх домог хуучаас улбаатай мэдээг бодот үнэн мэтээр олонтоо дурдсан байдгийг залруулах ёстой. XVIII зууны үед амьдарч асан Алшаагийн равжамба Данзандагвын зохион найруулсан “*Зүрхний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маани*” хэмээх хэлзүйн бичигт тус домгийг анхлан тэмдэглэжээ². Хожим уг бүтээлийг үндэс болгон бичсэн Агваандандарын “Хэлний чимэг”-т “*Ер монгол үсгийг хэн хүн ямар газар аль цагт зохиосон хэмээвээс, Өөлдийн хан Годаны үед Сажа бандид Гунгаажалцантан Лянь-Жоу хотод дөрөвдүгээр*

* Оосака их сургуулийн урилгын багш.

¹) Саган сэцэн, *Эрдэнийн товч*, Эх бичгийн судалгаа хийсэн М.Баярсайхан, Уб., 2011, 64-р тал.

²) *Early Mongolian Linguistic Texts*, Introduced Zh.Serjee, Treasures of Mongolian Culture and Tibeto-Mongolian Buddhism, Vol.4, Budapest, 2005, p. 28; “*Jirüken-ü tolta-yin tayilburi*” *oytaryui-yin mani kemekü sudur orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 2-3.

равжүнгийн харагчин туулай жил зохиосон буй”³ гэсэн байдаг. Харин занги Лхамсүрэнгийн “Алтан толь” хэмээх хэлзүйн бичигт “Анх монгол үсгийг баруун газрын их бандид лам Гунгаажалцаны гэгээнтэн тогтоон зохиосон Зүрхний толт хэмээх судраас эхэлж, үүсгэн журамласан ба хойно мөн газрын монлам ламын (Данзандагвыг хэлж буй. Д.З) зохиосон Зүрхний толтын тайлбар огторгуйн маани хэмээх судрыг гол болгож хэрэглэсээр...”⁴ гэж тэмдэглэсэн нь угтаа Гунгаажалцан монгол үсгийг бус монгол хэлзүйн бичгийг зохиосон гэдгийг зөв үнэлсэн хэрэг юм. Тэрхүү домгийг монгол бичгийн гаралтай холбон тайлбарлах нь үнэнээс хэтийдсэн дүгнэлт болох бөгөөд Ш.Лувсанвандан, Т.Пагва нарын тэмдэглэсэнчлэн⁵ одоогоор бидэнд мэдэгдэж буй хамгийн эртний журамласан хэлзүйн бичгийг зохиосон цаг үе, зохиогчийг тодлох баримт болно.

Хойч үеийнхээ мэргэдийн бүтээлд чухал нөлөө үзүүлж, “монгол үсгийн номлолгоо”, “...монгол үсгийн эндүүрэлгүй бодот гол мөнний тул богдсын журмын дагаваас мэргэдэд үл сонжигдмуй”⁶ хэмээтэл алдаршсан “Зүрхний толтын тайлбар” гэдэг үнэ цэнтэй сурвалжийг зохиогч нь Хайсанхүлэг хааны үед амьдарч асан, номт гурван улс хэмээх энэтхэг, төвд, монголын хэлнээ нэвтэрхий мэргэшсэн дуун ухаанч Чойжи-Одсэр билээ. Лувсанданзаны “Алтан товч”-д “Түүний хойно, мөн он хонин жилээ Өлзийт хааны дүү Хүлүг хаан хорин долоон насандаа их ор суув. Лам нь Чойжи-Одсэр буюу”⁷, “Эрдэнийн товч”-д “Тэндээс Дармабала-гийн хөвгүүн Хүлүг хаан цагаагчин могой жилтэй (1281 он), хорин наймнаа шар бичин жилээ (1308 он) хаан сууж, тойн Чойжи-Одсэр Номын гэрэл хэмээх хэлмэрчээр судар тарнийн хамаг номуудын ихэнхийг орчуулган, хоёр төрөөр хотлыг тэжээгээд дөрвөн жилээ хааны төрийг барин, гучин нэгнээ цагаагчин гахай жилээ (1311 он) халивай”⁸ гэсэн түүхэн тэмдэглэл буй.

Гунгаажалцан, Чойжи-Одсэр нарын хэлзүйн бичиг эх сурвалжаар уламжлан ирээгүй ч 18-р зууны үеийн хэлшинжлэлч равжамба Данзандагвын зохион найруулсан “Зүрхний толтын тайлбар, үсгийн эндүүрлийг харанхуйг арилгагч огторгуйн маани” хэмээн хэлзүйн бичгээс гол агуулгыг мэдэх боломжтой. Уг хэлзүйн бичгийн төгсгөлийн үгэнд “...Саж бандид хийгээд Пагва ламын зохиол ба Чойжи-Одсэрийн зарлигт бээр шүтэж равжамба Данзандагва бээр найруулсан” гэж тодорхой тэмдэглэжээ. Данзандагвын зохион найруулсан дээрх сурвалж буюу товч нэрээр “Огторгуйн маани” хэмээх хэлзүйн бичиг нь Чойжи-Одсэрийн “Зүрхний толтын тайлбар”-ын агуулгыг бүрэн мэдэж болохуйц дэлгэрэнгүй тайлбар хийснээрээ монгол хэлшинжлэлийн түүхэнд үнэ цэнтэй хэрэглэгдэхүүн болно.

³) Агывандан, *Mongyol üsüg-ün yosun-i sayitur nomlaysan kelen-ü čimeg kemegdekü orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 23-р тал.

⁴) Lhamusürüng, *Mongyol üsüg-ün yosun-i todurqayilan yarγaysan altan toli kemegdekü oroibai*, MKSDB, Köke qota, 1983, 38-р тал.

⁵) Ш.Лувсанвандан, *Эртний монгол хэлний фонемын систем нь*, Ш.Лувсанванданы бүтээлийн чуулган, 6-р боть, “Монгол хэлний авиа судлал”, Эмхэтгэж хэвлэлд бэлтгэсэн С.Батхишиг, О.Дэмчигмаа, Уб., 2010, 112-р тал; Т.Пагва, *Зүрхний толтын тайлбарыг судалсан тухай тэмдэглэл*, Уб., 1957, 12-р тал.

⁶) Vagindar-a, *Mongyol-un jaγun qorin γurban üsüg orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 73-р тал.

⁷) Лувсанданзан, *Алтан товч*, Эх бичгийн судалгаа хийсэн Ш.Чоймаа, Уб., 2011, 124-р тал.

⁸) Саган сэцэн, *Эрдэнийн товч*, Эх бичгийн судалгаа хийсэн М.Баярсайхан, Уб., 2011, 67-р тал.

Данзандагвын “Огторгуйн маани”-д дурдсанаар “*tere čay-tur Saskiya Pandida ... mongyol ulus-un üsüg-i ... er-e, em-e, ersü yurban-iyar čangya köndei be saγarmaγ yurban-iyar jokiyaγsan bolai. üsüg-üid inü: a e i, na ne ni, ba be bi, qa ke ki, γa ge gi, ma me mi, la le li, ra re ri, sa se si, da de di, ta te ti, ya ye yi, ča če či, ja je ji, va ve edeger bolai*”⁹ гэсэн байна. Ийнхүү Саж бандид Гунгаажалцан “Зүрхний толт”-доо *o, u, ö, ü* гэсэн уруулын дөрвөн эгшиг хийгээд түүгээр амилсан 56 үе үсгийг тэмдэглээгүй орхисон явдал судлаачдын анхаарлыг татдаг. Монгол хэлний түүхэн хөгжлийн үе шатуудын онцлогийг тусгасан баримт хэрэглэгдэхүүнээс улируулан үзвэл, уруулын эгшгүүд эрт үеэс нааш тогтвортой хадгалагдаж ирсэн нь тодорхой билээ. “Зүрхний толт”-ыг зохиохоос өмнөх үеийн монгол бичгийн дурсгалуудад ч нэгэнтээ хэвшин тогтсон байдаг. Гунгаажалцан уруулын дөрвөн эгшгийн зэрэгцээ хэлний гүн угийн *ng* гийгүүлэгчийг ч мөн дурдсангүй.

Энэ талаар Ш.Лувсанвандан “...бандид Гунгаажалцан монгол улсын үсгийн цагаан толгойн бүрэлдэхүүнийг *a, e, i, na, ne, ni, ba, be, bi* гэх мэтчилэн эр, эм, саармаг эгшгээр суурь болгосон дөчин хоёр үе-үсэг дээр *va, ve* хоёр үе үсгийг нэмэн дөчин дөрвөн үе үсгээр тогтоогоод үлдэх *o, u, ö, ü, no, nu, nö, nü, bo, bu, bö, bü* гэх мэтийн тавин зургаан үе, жич *ng* гийгүүлэгчийг *o, u* нь *f(a)* дээр *o (w)* нэмж, *ö, ü* нь *f(e)* дээр *o (w), i (y)* нэмж, *no, nu* нь *n* дээр *o, u* нэмж, *nö, nü* нь *n* дээр *ö, ü* нэмж, *bo, bu* нь *b* дээр *o, u* нэмж, *ng* нь *n* дээр *g* нэмж үүсэх нийлмэл үсэг гэж үзээд цагаан толгойн бүрэлдэхүүнд оруулаагүй бололтой”¹⁰ хэмээсэн оночтой гаргалгаа хийсэн билээ. Улмаар Д.Төмөртогоо “Саж бандид Гунгаажалцан “Зүрхний толт”-доо уруулын эгшгүүдийг оруулаагүй бус, харин *wa, we* хоёроор төлөөлүүлэн тэмдэглэсэн бололтой. Тодруулан хэлбэл, *o u* хоёрыг “*waw*”-аар, *ө ү* хоёрыг “*waw+yod*”-оор тэмдэглэсэн...”¹¹ гэж тайлбарлажээ. Ингэж үзвэл, Саж бандид Гунгаажалцан “...тэр цагийн монгол бичгийн хэлний авиаг *a, e, i, o, u, ö, ü, n, b, q, k, γ, g, m, l, r, s, d, t, y, č, j, w* гэж долоон эгшиг, арван найман гийгүүлэгч, бүгд хорин таван үсэг буюу авианд багтаасан нь илэрхий байна”¹².

Хоёр эрдэмтний дүгнэлт бидний сонирхлыг татаж байгаа хэдий ч Гунгаажалцан *va, ve* үеэр чухам ямар авиалбарыг хэрхэн тэмдэглэсэн нь тодорхойгүй байна. Түүнчлэн тэрбээр монгол бичгийн цагаан толгойн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо *va, ve* гэж *a, e* эгшгээр амилуулсан атал яагаад *vi* гэж *i* эгшгээр амилуулсангүй вэ? Хэрвээ *v (w)* үсэглэврийг хэлсэн бол *vi* гэж амилуулах боломж бүрэн байсан билээ. Өөрөөр хэлбэл, *vi* гэсэн үет үг тухайн үеийн монгол бичгийн дурсгалд цөөнгүй тохиолддог. Нөгөө талаар, Чойжи-Одсэр бүх гийгүүлэгчийг уруулын эгшгүүдээр амилуулахдаа “хязгаар дахь хоёр” буюу *va, ve* хоёрыг эс хувилгасны учир юу вэ гэх зэрэг эргэлзээтэй асуулт тулгарна.

⁹) *Early Mongolian Linguistic Texts*, Introduced Zh.Serjee, Treasures of Mongolian Culture and Tibeto-Mongolian Buddhism, Vol.4, Budapest, 2005, p. 28-29; “*Jirüken-ü tolta-yin tayilbur*” *oγarγui-yin mani ketekü sudur orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 3-р тал.

¹⁰) Ш.Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний бүтэц*, Тэргүүн дэвтэр, Авиа авиалбар хоёр нь, Уб., 1967, 4-р тал.

¹¹) Д.Төмөртогоо, *O wa we в “Jirüken-ü tolta” Сажа бандида Гунгааджалцана*, ОУМЭИХ:2, II боть, Уб., 1973, 163-165; Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд, Уб., 2002, 475-479.

¹²) Ш.Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний бүтэц*, Тэргүүн дэвтэр, Авиа авиалбар хоёр нь, Уб., 1967, 4-р тал.

Монгол бичгийн дурсгалд *w* үсэглэврээр *quvray* (Howre()), *bodistv* (BdisDwA), *vinai* (WineI), *nirvan* (Nirwea), *včir* (wci*), *nisvanis* (Nisweni_), *sugavadi* (SovEwedI), *virengūd* (WireehKoa) гэх мэт *v* гийгүүлэгч орсон харь үгийг зүй тогтолтой тэмдэглэсэн байна. Хэрэв Гунгаажалцан *béth* (*w*), *nún* (*e*) үсэглэврээр тэмдэглэж байсан *va*, *ve* үеийг хэлсэн бол *ва*, *вэ*, *ви* гэж бусад гийгүүлэгчийн адил гурван эгшгээр хувилгах байлаа. Гэвч түүний цагаан толгойн бүрэлдэхүүнд оруулсан *va ve* үеийг тэр цагийн монгол бичигт харь хэлний хэлбэрийг үсэгчлэн буулгасан *W+e*, *W+a* (*va/ve*) нийлэмжийн зэрэгцээ монгол хэл аялгуунд авиалагдах онцлогийг шууд тусгасан *o+e*, *O+T* (*ua/üe*) хувилбараар тэмдэглэж байсан гэх таамаглал дэвшүүлж байна.

Гунгаажалцан цагаан толгойн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зөвхөн монгол үгэнд тохиолдох үндсэн үсэглэврүүдийг оруулан тооцож, *o+e*, *O+T* нийлмэл хэлбэрээр *va/ve* үе-үсгийг тэмдэглэхээр журамлажээ. Тэрхүү *va/ve* үеийн монгол хэл аялгуунд авиалагдах байдал нь *ua* (*ya*), *üe* (*yэ*) нийлэмжтэй ойролцоо байсан биз. Үүнийг *BdisedOT ~ Bdisedwa*, *fserOT ~ fserwa*, *HorOT ~ Horwa* гэх зэргээр тэмдэглэдэг хувилбар бичлэг бүхий үгсээс харж болно. Агваандандарын “Хэлний чимэг”-т “*Бас ва, вэ хоёр монгол үгсэд буй бөгөөд ви, во, ву, вө, вү энэ таван үсэг монголын үгсэд үл хэрэглэх бөгөөд үсгийн дэвсгэрт ч үл хэрэгсгүй*”¹³, Лхамсүрэнгийн “Алтан толь”-д өмнөх учрыг нэгэн адил дурдаж “...цагаан толгойд хасчээ”¹⁴ гэсэн нь өмнөх таамгийг үнэмшилтэй болгож байна.

Гунгаажалцан монгол үсгийн цагаан толгойд *š*, *p* гийгүүлэгчийг бас оруулсангүй. “*Орчин цагийн монгол үгэнд тохиолдох š гийгүүлэгч нь угтаа i эгшигийн өмнө орсон s-ээс үүссэн, мөн p гийгүүлэгч нь одоо ч монгол үгэнд ховор хэрэглэгддэг байдлаас үзэхэд арван гурав-дөрөвдүгээр зууны үед энэ хоёр авиа монгол хэлэнд биеэ даасан фонем болоогүй байсан учир тэгж цагаан толгойнхоо бүрэлдэхүүнд оруулаагүй хассан байж магадгүй*”¹⁵ гэсэн Ш.Лувсанванданы санал үндэстэй боловч өгүүлэл бичигчийн хувьд арай өөр бодолтой байна.

Тэр үеийн монгол хэлэнд *š*, *p* авиа бие даасан авиалбарын үүрэгтэй байсан нь эргэлзээгүй боловч түүнийг ялган тэмдэглэх үсэглэврийн хувьд нэг мөр хэвшээгүй байжээ. Тухайлбал, XIII-XVI зууны монгол бичгийн дурсгалд *š* авиалбар орсон үсгийг *šastir* (*Zesdi* ~ Sesdi**), *šlüg* (*Zloit ~ Sloit*), *nisan* (*Nizea ~ Nisea*), *šagimuni* (*ZekumonI ~ SekumonI*), *šasin* (*Zesia ~ Sesia*) гэх мэтээр *š*, *s* үсэглэврээр харилцан адилгүй тэмдэглэсэн байна. Харин *p* гийгүүлэгч бүхий харь хэлний үгийг тэмдэглэхдээ *b* үсэглэврээр буулгасан жишээ *baday* {< Skr. *padaka*} *badm-a* {< Skr. *padmā*} *galba* {< Skr. *kalpa*} *jambu tib* {< Skr. *jambudvīpa*} *ubasi* {< Uig. *upāsi*} *udbal-a* {< Skr. *utpalā*} гэх мэтээр цөөнгүй тохиолдоно. Хэрэв авиазүйн талаас хандсан бол уг хоёр гийгүүлэгчийг цагаан толгойн бүрэлдэхүүнд оруулах ёстой. Гэвч Гунгаажалцан цагаан толгойн

¹³⁾ Агваандандар, *Mongyol üsüg-ün yosun-i sayitur nomlaysan kelen-ü čimeg kemegdekü orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 23-р тал.

¹⁴⁾ Лхамсүрэнг, *Mongyol üsüg-ün yosun-i todurqayilan γarγaysan altan toli kemegdekü oroibai*, MKSDB, Köke qota, 1983, 43-р тал.

¹⁵⁾ Ш.Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэлний бүтэц*, Тэргүүн дэвтэр, Авиа авиалбар хоёр нь, Уб., 1967, 5-р тал.

бүрэлдэхүүнийг тогтоохдоо авиазүй бус үсэгзүйн шалгуурыг гол болгосон учир *š*-ийг *s*, *p*-г *b* үсэглэврийн хувилбар (*allograph*) гэж үзээд оруулаагүй бололтой.

Нэгтгэн дүгнэвэл, Гунгаажалцан “Зүрхний толт”-доо тэр үеийн монгол хэлний авианы тогтолцоог харгалзалгүй зөвхөн тэмдгийн буюу үсэглэврийн онцлогийг харгалзаж, цагаан толгойн бүрэлдэхүүнийг тодорхойлсон ажээ. Тийм учраас *ng* нийлмэл үсэглэврийг цагаан толгойн бүрэлдэхүүнд оруулсангүй. Учир нь түүний бүтцэд орсон *n*, *g* үсэглэвэр цагаан толгойн бүрэлдэхүүнд багтсан тул түүнийг орхисон байна. Өөрөөр хэлбэл, *ng* нь хэлний гүн угийн *ŋ* авиаг заах үүрэгтэй ч түүнийг тэмдэглэх тэмдэгтийн хувьд *n*, *g* үсэглэврийн нийлэмж болох учир бие даасан үсэг гэж тооцсонгүй. Үүний нэгэн адил *o*, *u* нь *f* (*áleph*) *o* (*waw*), *ö*, *ü* нь *f* (*áleph*), *o* (*waw*), *i* (*yod*) тус тус нийлсэн нийлмэл үсэглэвэр болох ажээ. Энэхүү *o* (*waw*) тэмдэгт нь *va/vэ*-гийн монгол хэлнээ авиалагдах онцлогийг тусгаж тэмдэглэсэн *o+e*, *O+T* (*ua/üe*) үед орсон *o* (~ *O*) үсэглэвэр болно. Тэгэхээр Гунгаажалцаны “Зүрхний толт”-д уруулын эгшгүүдийг оруулаагүй явдал нь авиазүйн учир холбогдолтой зүйл биш бөгөөд зөвхөн үсэглэвэр буюу тэмдэгтийн үүднээс хандаж, монгол хэлний цагаан толгойн бүрэлдэхүүнийг 44 үе-үсгээр томьёолсон хэрэг болох юм.

Харин Саж бандид монгол хэлний үндсэн авиануудыг эгшиг, гийгүүлэгч хэмээн хоёр хуваагаад, эгшгээ эр, эм, эрс гэж эртний энэтхэг хэлшинжлэлийн уламжлалаар ангилсан нь орчин цагийн монгол хэлшинжлэлийн үүднээс үзвэл асар том ололт юм. Одоогоос найман зууны тэртээ дуун ухаанч Гунгаажалцаны нээж томьёолсон эгшиг авианы байрлалын хууль өдгөө ч үнэ цэнээ алдаагүй байна.

Данзандагвын “Огторгуйн маани” дахь “...энд монгол үсгийн номлолгоо Чойжи-Одсэр дээд богд тэрбээр зохиосон Зүрхний толт номлохуйд гурван: **алин цагт гарсан уг хийгээд үсгийн ялгал ба махбодын ялгал** болой. Анхад гурван: **Монголд шашин гарсан цаг хийгээд түүнийг монголд дэлгэрүүлсэн ба монгол үсгээр ном орчуулсан болой**” гэсэн мэдээг эш үндэс болговол уг зохиол нь монгол шашин ба үсэг бичгийн түүх, үсгийн ялгал, махбодын ялгал хэмээх гурван үндсэн бүлэгтэй байжээ. Монгол үсгээр ном орчуулсан хийгээд үсэг бичгийн түүхийг өгүүлсэн хэсэгт Саж бандид Гунгаажалцан, Пагва лам Лодойжалцан нарын шашин номын үйлсийн тухай тодорхой дурдсан билээ.

Чойжи-Одсэрийн “Зүрхний толтын тайлбарт”-т монгол хэлний цагаан толгойг хэрхэн тодорхойлсныг эш татъя. Тэнд “*a aca o u qoyar, e ece ö ü qoyar, na aca no nu qoyar, ne ece nö nü qoyar ... ya aca yo yu qoyar, ye ece yö yü qoyar böged cingγ-a arban dörben kiged köndei arban dörben-ece qosiyad qosiyad qubilyaju tabin jiryuyan üsüg... ijayurun döcün dörben deger-e nemebesü jayun üsüg..., ba üsüg deger-e inü qoyar cikin metü bičiged pa kiged tegünčilen sa üsüg-ün gejigen-dür qoyar čig talbiyad ša ba, basa jalyan bičiküi-dür ja üsüg-i ča metü bičiged ögülegdeküi ja kiged ... qubilyaqui anu ijayur-i dayan medegdeküi kemegsen tere metü bögesü pa pe pi po pu pö pü, ša še ši šo šu šö šü, ja je ji jo ju jö jü kiged ng kiged ja yin deger-e nigen silbi bičiged ra debisker ögbesü iyar ba edeger-lüge jayun qorin yurban üsüg...*”¹⁶ хэмээн тодорхойлсон байна.

¹⁶⁾ *Early Mongolian Linguistic Texts*, Introduced Zh.Serjee, Treasures of Mongolian Culture and Tibeto-

Чойжи-Одсэр *o, u, ö, ü* уруулын дөрвөн эгшгээр амилуулж *no, nu, nö, nü, bo, bu, bö, bü* гэх мэтчилэн 56 үе-үсгийг бүтээгээд Гунгаажалцаны томьёолсон 44 үе-үсэг дээр нэмж 100 болгожээ. Түүнчлэн *b* үсэглэврийн дээр хоёр чих мэт бичээд *p, s* үсгийн гэзгэнд хоёр цэг тавиад *š, j*-ийн үгийн дунд орох хэлбэрийг *č* мэт болгож, тэдгээрийг долоон эгшгээр хувилган хорин нэгэн үе-үсэг болгосон байна. Тэгээд *ng, iyar* хоёрыг нэмж 123 гурван үсэг болгосон бөгөөд чухамдаа монгол үсгийн цагаан толгойг 121 үе-үсэг, нэг гийгүүлэгч (*ng*), нэг бүтээвэрт (*iyar*) багтаан зохиожээ. Үүнээс үзэхэд Чойжи-Одсэр *a, e, i, o, u, ö, ü, n, b, q/k, γ/g, m, l, r, s, d, t, y, č, j, v, p, š, ng* гэсэн долоон эгшиг, арван долоон гийгүүлэгчээр тэр цагийн монгол үсгийн цагаан толгойн бүрэлдэхүүнийг тодорхойлон гаргажээ.

Энэхүү 123 үе-үсгийн дотор ‘*j*’ гийгүүлэгчийн эхэн (J), дунд (j) орох хэлбэрийг тус тусад нь долоон эгшгээр амилуулснаас үүдэж, *ja*-гийн бүлгийн долоон үе-үсгийг давхардуулсан байна. Өөрөөр хэлбэл, Гунгаажалцаны 44 үе үсгийн доторх ‘*ja*’-г (Je) долоон эгшгээр амилуулахын зэрэгцээ өөрийн нэмж оруулсан үгийн дунд орох ‘*ja*’-г (je) мөн адил хувилгажээ. Тийм учраас Чойжи-Одсэрийн бүртгэн томьёолсон 121 үе-үсгээс тэрхүү давхардсан долоон үе-үсгийг хасах нь зөв болно. Түүний дээр *iyar* бүтээврийг цагаан толгойгоос хасах нь зүйн хэрэг. Ингэвэл Чойжи-Одсэр 114 үе-үсэг, нэг гийгүүлэгч (*ng*) үсгээр монгол бичгийн цагаан толгойг бүртгэн тогтоосон байна. Тэрбээр цагаан толгойн бүрэлдэхүүнийг тогтоохдоо авиазүй-үсэгзүйн тэгш зарчмаар хандаж, ул үндэстэй тодорхойлсны учир түүний бүтээл дараа дараагийн хэлзүйчдэд хүчтэй нөлөө үзүүлсэн ажээ.

Эцэст тэмдэглэхэд, уламжлалт хэлшинжлэлийн сурвалж бичгүүдэд томьёолсон монгол хэл судлалын үзэл хандлагыг хянамгай шинжилж, авах гээхийн ухаанаар хандах нь монгол хэлшинжлэлийн түүхийг үнэн зөв тодорхойлж, зарим ээдрээтэй асуудлыг учгийг онож тайлахад чухал ач холбогдолтой юм. Төгсгөлд нь монгол бичгийн дурсгалд тэмдэглэсэн хийгээд Гунгаажалцан, Чойжи-Одсэр нарын бүртгэн тогтоосон монгол үсгийн цагаан толгойг хүснэгтээр үзүүлье.

№	Дурсгал	Гунгаажалцан	Чойжи-Одсэр
1	<i>a</i>	<i>a</i>	<i>a</i>
2	<i>e</i>	<i>e</i>	<i>e</i>
3	<i>i</i>	<i>i</i>	<i>i</i>
4	<i>o</i>	-	<i>o</i>
5	<i>u</i>	-	<i>u</i>
6	<i>ö</i>	-	<i>ö</i>
7	<i>ü</i>	-	<i>ü</i>
8	<i>n</i>	<i>n</i>	<i>n</i>
9	<i>q/k</i>	<i>q/k</i>	<i>q/k</i>
10	<i>γ/g</i>	<i>γ/g</i>	<i>γ/g</i>
11	<i>b</i>	<i>b</i>	<i>b</i>

Mongolian Buddhism, Vol.4, Budapest, 2005, p. 33; “*Jiriken-ü tolta-yin tayilburi*” *oyтарыи-yin mani kemekü sudur orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 7-8.

12	<i>s</i>	<i>s</i>	<i>s</i>
13	<i>š</i>	-	<i>š</i>
14	<i>t</i>	<i>t</i>	<i>t</i>
15	<i>d</i>	<i>d</i>	<i>d</i>
16	<i>l</i>	<i>l</i>	<i>l</i>
17	<i>m</i>	<i>m</i>	<i>m</i>
18	<i>j</i>	<i>j</i>	<i>j</i> ЭХЭНД (J) ¹⁷
			<i>j</i> ДУНД (j)
19	<i>č</i>	<i>č</i>	<i>č</i>
20	<i>y</i>	<i>y</i>	<i>y</i>
21	<i>r</i>	<i>r</i>	<i>r</i>
22	<i>p</i>	-	<i>p</i>
23	<i>v</i>	<i>va/ve</i> →* <i>ua/üe</i>	<i>va/ve</i> →* <i>ua/üe</i>
24	<i>ng</i>	-	<i>ng</i>
25	-	-	<i>iyar/iyer</i>

¹⁷⁾ Чойжи-Одсэр ‘j’ гийгүүлэгчийн үгийн эхэн ба дунд орох хэлбэрийг ялгаж, тус бүрийг долоон эгшгээр амилуулснаар 123 үсгийн дотор уг гийгүүлэгчийн үе-үсэг давхардан орсон байна.

ABSTRACT

An Explanation on the 44 alphabetic letters by Gungaajaltsan and 123 by Choiji-Odser in Traditional Linguistic Sources

Analyzing survey the traditional linguistic sources is an important step in historical study of the Mongolian grammar. This paper gives a definite explanation of how to understand on the 44 alphabetic letters by Gungaajaltsan and 123 by Choiji-Odser. In this paper I made following offers:

Gungaajaltsan hasn't counted *o*, *u*, *ö* and *ü* in Mongolian alphabet because these letters consist the compound graphemes such as '*áleph+waw*' and '*áleph+waw+yod*' like '*ng*'. The reason for this is, he has emphasized the graphic representation without considering phonetic form.

Choiji-Odser has counted seven vowels, seventeen consonants and one morpheme (*iyar*) in the Mongolian alphabet. The sixteen consonants except '*ng*' are formed with seven vowels. Furthermore, he has added four consonants such as *p*, *š*, *j* which have been changed the glyphs *b*, *s* and *j* at the beginning of a word as well as *ng*. The letter '*j*' is written the difference when appearing at the beginning and in the middle of a word. Although they are formed with the vowels which are at the beginning (J) and in the middle (j) of a word. Obviously, it has been shown Choiji-Odser made some mistakes when he described the Mongolian alphabet.